

### 13-Р ЗУУНЫ “МОНГОЛ УЛС”-ЫН НЭР ТОМЬЁОГ МОНГОЛ ХЭЛНЭЭС ХЯТАД ХЭЛ РҮҮ ОРЧУУЛАХ АСУУДАЛ

*Ду Шивэй\**

2006 он бол Чингис хаан 1206 онд Монголын нэгдсэн улсыг байгуулсны 800 жилийн ой. Энэ 800 жилийн хугацаанд дэлхий ертөнц асар их өөрчлөгдөн шинэчлэгдсэн ч 21-р зууны эхээр Чингис хаан дахин бүх дэлхийн анхаарал татсан мэдээллийн содон хүн болж, зарим хэвлэлийн байгууллагууд түүнийг “Мянганы агуу хүн”-ээр өргөмжилсөн.

13-р зуунаас эхлээд дэлхийн газар бүр Чингис хаан болоод түүний байгуулсан улсын тухай ном, өгүүллүүд тасралтгүй бичигдсээр байна. Зарим хүний тооцоолсноор, одоо дэлхий дээр 60 гаруй улс газар, мэргэжлийн судалгааны баг Чингис хааны түүхийг тусгайлан судалж байна. Өнөөгийн мэдээллийн сүлжээний үед 70000 гаруй веб хуудсууд дээр Чингис хаантай холбоотой мэдээллүүд цацагдсаар байна. Түүний дотор 40000 гаруй нь хятад хэл дээрх веб хуудсууд байна<sup>1</sup>. Энэ тоо баримт Хятад улс Олон улсын монгол судлалын нэг гол төв болж байгааг илтгэнэ.

Харин дотоод гадаадын ихэнх ном, өгүүлэл, мэдээ баримтуудад Чингис хаан болоод түүний байгуулсан улсын нэр томьёог хятад хэл дээр орчуулах, илэрхийлэх тал дээр оноож өгсөн нэр үгийн төрөл зүйл маш олон байна. Жишээ нь: 蒙古 - Монгол, 大蒙古 - Их Монгол, 蒙古国 - Монгол Улс, 大蒙古国 - Их Монгол Улс, 蒙古大国 - Монголын Их Улс, 蒙古帝国 - Монголын Эзэнт Улс, 大蒙古帝国 - Их Монголын Эзэнт Улс, 蒙古大帝国 - Монголын Их Эзэнт Улс, 蒙古汗国 - Монголын Хаант Улс, 大蒙古汗国 - Их Монголын Хаант Улс, 蒙古合汗国 - Монголын Их Хаант Улс, 元朝 - Юань гүрэн, 大元朝 - Их Юань гүрэн, 大元帝国 - Их Юань Эзэнт Улс, 元朝大帝国 - Юань гүрний Их Эзэнт Улс, 大元蒙古国 - Их Юань Монгол Улс, 大朝蒙古国 - Их гүрэн Монгол Улс, 大朝 - Их гүрэн, түүнээс гадна 草原帝国 - Талын Эзэнт Улс, 游牧帝国 - Нүүдэлчдийн Эзэнт Улс, 成吉思汗国 - Чингис хаан улс гэх мэт аль нь зөвийг мэдэхгүй 20 гаруй төрөл байна.

Гэвч түүхийн эх сурвалж материалд тэмдэглэснээр, “Чингис хаан (成吉思)” нэр болоод түүний байгуулсан улсын нэрийг нь 1206 онд анх удаа монгол хэл дээр албан ёсоор тогтоон хэрэглэсэн байна.<sup>2</sup> (Зураг 1) “Их Монгол Улс” энэ нэрийг монгол хэл дээр Гүюг хааны уйгур монгол бичгээр бичсэн тамган дээрээс харж болно.<sup>3</sup> (Зураг 2) 1206 оноос хойш “Монгол Улс”, “Их Монгол Улс” гэсэн нэрийг янз бүрийн

\* Ду Шивэй - Хятадын Нийгмийн Ухааны Академийн Угсаатны зүй, хүн судлалын хүрээлэн, доктор (Ph.D)

хэл дээр хөрвүүлэн хэрэглэсэн бөгөөд хятад хэлэнд мөн энэ үеэс хойш түүхийн янз бүрийн үе шатанд тухайн цаг хугацааны онцлогийг агуулаад олон янзаар орчуулан хөрвүүлсэн байна.

“成吉思汗 (Чингис хаан)” энэ ханз үсгийн нэр томъёог зарим түүхийн ном материалд “成吉思合罕”, “騰吉斯汗” гэж өөр ханз үсгээр тэмдэглэсэн байдаг боловч өнөө үед аль ч газрын хятад хэлэнд зөвхөн “成吉思汗 (Чингис хаан)” гэсэн энэ нэр томъёог тогтоон хэрэглэж байна. Энэ нэр томъёог эс хэрэглэвээс буруу үсэг, өөр хүн гэж үздэг. Гэтэл тухайн үеийн монгол хэлэнд тусгайлан оноож хэрэглэсэн “Их Монгол Улс” гэсэн нэрийг өнөөдөр хятад хэлэнд ямар ч тогтсон нэр томъёогүй олон янзаар хөрвүүлэн хэрэглэж байгаа нь судлаач мэргэжилтнүүдийн анхааран нарийн судлах асуудал болоод байна.

Энэ асуудалд тааруулан, хятад хэлэнд ийм олон нэр томъёо гарсны шалтгааныг судлаач дараах 3 талтай гэж үзэж байна. Үүнд:

1. Монгол хэлний “Их Монгол Улс” энэ нэр томъёон дахь “Их”, “Монгол”, “Улс” гэсэн дан үгсийн гарал үүсэл, соёлын утга санааг дутуу ойлгосон эсхүл ташаа ойлгосон. Учир нь “Ямар ч хэлний үгийн сан түүний соёл, ёс заншилтай салшгүй холбоотойгоор зогсохгүй соёлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үгийн утга санаа тусгай тогтоосон соёлд хязгаарлагдан хэрэглэгддэг. Түүний дотор үгийн сан нь бас зөвхөн хэлний орчин дунд сая өөрийн бодит утгаа олж бүрэн дүүрэн утга санааг илэрхийлдэг”.<sup>4</sup> Иймд түүхийн янз бүрийн үе шатан дахь хятад хэлэнд “тухайн үеийн жинхэнэ бодит монгол соёл, хэлний орчин”-г анхааран үзээгүйтэй, цаашлаад хүн соёл судлалын үндсэн онолын зарим асуудалтай холбоотой.

2. Орчин үе (20-р зууны 30-аад он)-ийн хятад хэлний орчуулагчид болон хэрэглэгчид 13-р зууны үеийн монгол, хятад хэлний орчин ба соёлын ойлголтын талаархи мэдлэг дутуу эсхүл ташаа ойлгосон. Мөн Дундад Ази болон барууны судалгааны ном материал дээр 19-20-р зууны эхэн үеийн Дундад Ази болон барууны соёл, хэлний орчноос ирсэн ойлголтоор оноосон нэр томъёогоор “Их Монгол Улс” энэхүү нэр томъёоны хятад нэр томъёог өгсөн.

3. Өнөө үеийн ихэнх хэрэглэгчид болон уншигчид энэхүү 13-р зууны “Их Монгол Улс” тусгай нэр томъёоны утга санааг орчин үеийн нийгмийн үзэл санааны онол болон сэтгэн бодох арга барилаар ойлгож хятад хэл дээрх нэр томъёог оноон өгсөн. Энэ нь газар нутгийн болон улс төрийн үзэл санааны ташаа ойлголт, цаашлаад үл ойлголцох хэл маргаан үүсгэхэд хүрнэ.

Иймд судлаач өөрийн зарим ойлголт санааг тайлбарлая. Та бүхэн засан залруулна уу.

1. Монгол хэлний “Их Монгол Улс” энэхүү нэр томъёон дахь “Их”, “Монгол”, “Улс” гэсэн дан үгсийн гарал үүсэл, соёлын утга санааны талаархи ойлголт:

а) Юуны өмнө энэ 3 дан үг эртний монгол хэлнээс үүсэлтэй учраас монгол хэлний язгуур хэлний соёлын орчинг агуулж байна.

б) “Монгол” энэ үг нь монгол хэлний нийлмэл нэр үг. Энэ үг нь хятад хэл дээр анх 7-р зууны үед Тан улсын үед гарч ирсэн. “蒙兀”, “膝骨” зэрэг олон ханз үсэг байгаа нь тухайн үед Шивээ аймгийн доторхи “蒙兀-室韦 (Монгол -Шивээ)” аймгийг тусгайлан зааж байна.<sup>5</sup> 13-р зуунаас хойш “蒙古 - Монгол” энэ үгийг хятад хэл дээр монгол хэлний аялгыг тааруулан орчуулсан бөгөөд өнөөдөр монгол үндэстэн болоод Монгол Улсын нэр томъёо болон хэрэглэгдэж байна.

с) “Улс” энэ үг монгол хэлний нэр үг, нэр үгийн олон тоо. Энэ үгийн монгол хэлэн дэх утга санааг хятад хэлэнд хөрвүүлбэл “人们 (单个人的复数) - хүмүүс, 大众 - олон түмэн”, “群体 - бөөгнөрөл, “百姓 - ард”, “人民 - ард түмэн”, “族群 - угсаатан, “群体领地 - бөөгнөрөн оршин суух газар”, “领地 - газар”, “家园 - газар нутаг, “家国 - нутаг орон”, “国家 - улс орон” зэрэг утгатай. Иймд “Улс” энэ үг хүн болоод газар орныг аль алиныг нь зааж байгаа тул хятад хэлэн дэх монгол хэлний утгыг “Ямар нэг цусан төрлийн холбоо хамааралтай нэгэн угсаа гаралтай хүмүүс” эсхүл “Ямар нэг цусан төрлийн холбоо хамааралтай нэгэн угсаа гаралтай хүмүүсийн оршин байгаа газар” гэж ойлгож болно. Өнөө үеийн монгол хэлэнд гол төлөв улс орныг заасан утгатай байна. Хятад хэлэнд монгол хэлний аялгыг дагуулан “乌勒思”, “乌鲁木齐”, “兀勒斯” зэрэг ханз үсгээр зарим үед “家国 - нутаг орон”, “国 - улс”, “国家 - улс орон” гэсэн ханз үсгээр орчуулан бичсэн байдаг.

д) “Их” энэ үг монгол хэлний тэмдэг нэрийн хүч оруулсан хэлбэр. Энэ үгийн монгол хэлэн дэх утга санааг хятад хэлэнд хөрвүүлбэл “极多 (多的最高形式) - хязгааргүй олон”, “很多 (多 - маш олон”, “非常 (多) - асар олон”, “特别 (多) - онцгой олон”, “大量的 - олонхи”, “极多并且极大 - хязгааргүй олон төдийгүй хязгааргүй том” зэрэг утгатай. Иймд хятад хэлэнд тоо хэмжээ хязгааргүй олон төдийгүй хязгааргүй том гэсэн монгол хэлний утгыг зааж байна. Хятад хэлэнд хөрвүүлсэн “大” гэсэн ханз үсэг нь монгол хэлний “их, том” гэсэн утгатай тохирч байна. Гэвч “大 - том” гэсэн үг нь орон зай заасан тэмдэг нэр тул “их” гэсэн үгтэй харьцуулбал бага зэрэг утга санааны ялгаатай байна.

Тэгвэл “Их Монгол Улс” гэсэн тусгайлан оноосон улсын нэрийн монгол хэлний хятад хэлэн дэх утга санааг “极多的一蒙古 (式) 族体的 - 地域领地 - хязгааргүй олон - монголжин угсаатан - эзэмших газар” гэж ойлгож болно.

Хятад хэл дээр яагаад ингэж ойлгож байна вэ? 1206 оноос өмнө “Монгол” гэж цусан төрлийн холбоотой хүн ам цөөн (тухайн үед ойролцоогоор хэдэн арван мянган хүн байсан), газар нутаг том биш (тухайн үед ойролцоогоор хэдэн арван мянган хавтгай дөрвөлжин километр) дан ганц овог аймаг байсан. Гэвч Тэмүжин өөрийн ураг төрөл, угсаа гаралтай хүмүүсийг нэгтгэн, 30 гаруй жилийн аян дайныг туулан 1206 онд янз бүрийн улсын 95 мянгат ноёнттой, сая орчим хүн амтай, хэдэн арван сая хавтгай дөрвөлжин километр газар нутагтай “Монгол Улс”-ыг байгуулсан. “Судрын чуулган”-д тэмдэглэснээр: “Одоогийн байдлаар Чингис болоод түүний угсаа төрлийнхний хөгжил цэцэглэлт, тэдний монгол үндэстэнтэй холбоотойгоор түрэг, жалайр, татаар, ойрад, вангуд, хэрэйд, найман, тангуд зэрэг аймгийнхан өөрсдийгөө дөвийлгөн сайрхахын төлөө мөн монгол хүн гэж нэрийдэх боловч эрт үед тэд нар энэ нэрийг огт хүлээн зөвшөөрдөггүй байсан. Гэвч энэ цагаас хойш тэдний үр удам бүгд өөрсдийгөө монгол хүн гэж дуудах болсон”. “Учир нь тэдний гадаад төрх, шинж байдал, нэр, хэл, ёс заншил болоод үйл хөдлөл нь ойролцоо (гэвч эртний үед тэдний хэл, ёс заншил бага зэрэг ялгаатай байсан), одоо хятан, зурчид, ханхас, уйгур, чинча, туркмен, харлу, харчин зэрэг үндэстэн, бүх эзлэн дагуулсан үндэстэн болоод монгол хүмүүс дунд өссөн да ши үндэстэн (иран) тэд бүгд монгол үндэстнээр дуудагдах болсон. Энэ нь нэр төр, ашиг сонирхолтой холбоотой байсан.”<sup>6</sup> Мөн энэ үед Монголын өндөрлөгт анх удаа монгол үндэстнүүдийг нэгтгэсэн “Монголжин” улс бий болж, Чингис хаан эзлэн дагуулсан бүх нутгаа өөрийн эх, дүү, 4 хүүдээ хүн, мал, эд барааны хэмжээгээр хуваарилан аравт ноён, зуут ноён, мянгат ноён, арван мянгат ноён гэсэн тодорхой тоотой хуваасан.<sup>7</sup> Энэ нь тодорхой газар нутгийн хуваарилалт биш байсан. Нүүдэлчдийн нүүдлийн ахуй амьдралтай холбоотойгоор тэдэнд тогтсон газар нутгийн хэмжээний талаар тодорхой ойлголт байгаагүй. Энэ нь газар тариалангийн нийгэм дэх тодорхой тогтсон газар нутгийн хэмжээний талаархи ойлголттой адилгүй. Цаашлаад хятад хэлэн дэх “大” ба “国” энэ 2 ханз үсгийн хэл соёлын орчин монгол хэлэн дэх “Их” ба “Улс” гэсэн 2 үгийн хэл соёлын орчинтой харьцуулбал маш их ялгаа байна. Мөн тухайн үеийн улс нь “Хэдийгээр нэг хүний эрхэт хаант улс мэт боловч үнэн хэрэг дээрээ үр ач, ах дүү нар нь бүгд улсын эрх, эд хөрөнгийг хуваан эзэмшдэг байсан”.<sup>8</sup> Иймд “Их Монгол Улс” нь олон үе залгамжилсан овог аймгуудыг нийлүүлэн нэгтгэсэн улс болно.

“Монголжин улс” энэ нэрийн хүн соёл судлалын орчны талаар Өвөр Монголын эрдэмтэн Рэнцэн гуай ингэж тайлбарласан: Хамаг Монголын хэлэнд үндэслэсэн эртний монгол хэлэнд хамаарах угсаатан нийтийн хэл... Ингэснээр “Монголжин улс - 蒙古式的人众”-ын талаар

угсаатны төсөөлөл бий болсон.<sup>9</sup> Эндээс тухайн үеийн Монгол улс болоод монгол угсаатны үүсэн бий болох эхэн үеэс л угсаатан судлал ба хүн судлалын онол дахь “нийлүүлэх, байгуулах, нийтээр хүлээн зөвшөөрөх” гэсэн онцлог байсан гэж хэлж болно.<sup>10</sup>

Эндээс харахад, монгол хэлний соёлын утга санааг өөр цаг үе, өөр өөр газар орон, өөр өөр хэл соёлын орчин, өөр өөр үзэл суртлын дунд, янз бүрийн орчуулагч болоод хэрэглэгчид аялга тааруулах, шууд, өөрчлөн найруулах, утга санаагаар орчуулах гэсэн 4 төрөл орчуулгын журмаар орчуулж янз бүрийн нэр томъёо бий болгосон. Эдгээр орчуулсан нэр томъёон дахь хамгийн хүнд асуудал бол хүлээн авч буй үг эсхүл орчуулах үг дотор яг тохирсон үг болоод бүтцийг олох явдал юм. Мөн өнөөдөр орчуулагч болоод хэрэглэгчдэд тохиолдож байгаа хүндрэлтэй асуудал бол орчуулах үгийн утга санааг хэлний орчны утга санаатай нийцүүлэн гүнзгий ойлгох. Юуны өмнө тухайн үгийн монгол хэлний хэл соёлын орчин дахь нийгэм болоод сэтгэхүйн чадавхийг ойлгох хэрэгтэй. “Сэтгэхүйн чадавхи бол хүн бодит байдлыг танин мэдэх арга, нийгмийн чадавхи бол хүмүүсийн хоорондын харилцааны арга зам гэж ойлгож болно. Сэтгэхүйн чадавхи гол нь дотоод шинж чанартай, хийсвэр, нийгмийн чадавхи нь гадаад шинж чанартай хүмүүсийн хоорондох харилцаа юм”.<sup>11</sup>

Гэвч “Их Монгол Улс” энэхүү 13-р зуунд оноосон улсын нэрийг өнөөдөр хятад хэлэн дээр яаж тодорхой дүрэм журманд үндэслэж тогтоосон хэл зүйн дүрэмтэй оновчтой нэр томъёо болгон тогтоох вэ?

2. Судлаачийн одоо монгол хэлнээс хятад хэл дээр орчуулагдаад байгаа нэр томъёоны талаархи ойлголт:

а) “蒙古, 大蒙古, 蒙古国, 大蒙古国, 蒙古大国” зэрэг эдгээр нэр томъёонууд нь аялга даган болон шууд орчуулах журмаар хятад хэл дээр орчуулагдсан илэрхий байна. Гэвч “Их Монгол Улс” энэхүү 13-р зуунд оноосон улсын нэрийн монгол хэлний үгийн утга санаа “极多的一蒙古式族体的一地域领地 - хязгааргүй олон – монголжин угсаатан – эзэмших газар”-ын бүтэн цогц агуулгаас харахад, энэ төрөл орчуулсан нэр томъёонууд нь хэлний утга санаа, үгийн чанар оновчгүй зэрэг хэл зүйн дүрмийн асуудал байна. “蒙古, 大蒙古, 蒙古国” зэрэг эдгээр нэр томъёонууд нь хэтэрхий хялбар өрөөсгөл, үгийн утга санааг бүрэн бүтэн агуулаагүй, “大蒙古国” энэ нэр томъёог хамгийн анх Мөнх хааны үеийн бомбын ёс суртахууны хөшөөний бичгэн дээр хятад хэл дээр орчуулан бичсэн<sup>12</sup> байдаг. “蒙古大国” энэ нэр томъёоны хувьд хятад хэлний дүрмийн бүтэц болоод хятад хэлний соёлын утга санаа бүр оновчгүй. Иймд эдгээр нэр томъёонууд нь тухайн нэр томъёоны

дотоод агуулгыг бодитоор илэрхийлж чадахгүй байна. Эдгээр нэр томъёонууд нь монгол хэлнээс хятад хэл дээр орчуулагдсан ном бичгийн материалууд дээр өргөн хэрэглэгдэж байна.

б) “蒙古帝国, 大蒙古帝国, 蒙古大帝国, 草原帝国, 游牧帝国, 成吉思汗帝国” зэрэг эдгээр нэр томъёонууд нь өөрчлөн найруулах, утга санаагаар орчуулах журмаар хятад хэл дээр орчуулагдсан. Орчин үе (20-р зууны 30-аад он)-ийн хятад хэлний орчуулагчид болон хэрэглэгчид 19-20-р зууны эхэн үеийн барууны соёл, хэлний орчноос ирсэн ойлголтоор оноосон хятад нэр томъёог хэрэглэж байна. Гэвч “Их Монгол Улс” энэхүү 13-р зуунд оноосон улсын нэрийн монгол хэлний үгийн утга санаа “极多的一蒙古式族体的一地域领地” – хязгааргүй олон – монголжин угсаатан – эзэмших газар”-ын бүтэн цогц агуулгаас харахад, эдгээр нэр томъёонууд дотор бас газар нутгийн болоод улс төрийн үзэл суртлын талаархи ташаа ойлголт байна. Эдгээр нэр томъёонууд нь Европ, Америк, Японоос хятад хэл дээр орчуулагдсан ном бичгийн материалууд дээр өргөн хэрэглэгдэж байна.

с) “蒙古汗国, 大蒙古汗国, 蒙古合汗国” зэрэг эдгээр нэр томъёонууд нь өөрчлөн найруулах, утга санаагаар орчуулах журмаар хятад хэл дээр орчуулагдсан. Эдгээр нэр томъёонуудыг Дундад Ази түрэгийн хэл соёлын орчноос ойлговол, Дундад Ази түрэгийн хэл соёлын орчны сэтгэхүйгээр оноон тогтоосон. Гэвч “Их Монгол Улс” энэ 13-р зуунд оноосон улсын нэрийн монгол хэлний үгийн утга санаа “极多的一蒙古式族体的一地域领地” - хязгааргүй олон - монголжин угсаатан – эзэмших газар”-ын бүтэн цогц агуулгаас харахад, эдгээр нэр томъёонууд дотор бас л тодорхой газар нутгийн болоод хэсэг цаг хугацааны улс төрийн үзэл суртлын талаархи ташаа ойлголт байна. Эдгээр нэр томъёонууд нь Дундад Азиас хятад хэл дээр орчуулагдсан ном бичгийн материалууд дээр өргөн хэрэглэгдэж байна. “蒙古汗国” энэ нэр томъёо өнөөдөр Хятадын эрдэм шинжилгээний хүрээлэлд өргөн хэрэглэгдэж байгаа бөгөөд гол төлөв 1206-1271 оны үеийн Монголын хааны эрхэт улсыг илэрхийлж байна.

д) “元朝, 大元朝, 大元帝国, 元朝大帝国, 大元蒙古国” зэрэг эдгээр нэр томъёонууд нь Хятадын түүхийн эх сурвалж бичигт үндэслэвэл, Хубилай хаан 1271 онд улсын нэрийг өөрчилснөөс хойш “易经”-д дурдсан “大哉乾元” - хамгийн том гэж сансар ертөнц” гэсэн үгээс бий болсон. Мөн судлаач “大” ба “元” энэ 2 ханз үсгийн хэрэглээ бүр “Их Монгол Улс” нэрний “Их” гэсэн үгний хятад хэл дээр орчуулсан утгатай тохирно гэж үзэж байна. Эдгээр нэр томъёонууд нь Хятадын

түүх соёлд илэрхий нөлөөлсөн бөгөөд хятад хэлний орчноос ойлговол, хятад хэлний соёлын орчин ба газар нутгийн үзэл суртлын сэтгэхүйн талаас оноон тогтоогдсон. Гэвч “Их Монгол Улс” энэхүү 13-р зуунд тогтоосон улсын нэрийн монгол хэлний үгийн утга санаа “**极多的一蒙古式族体的一地域领地** - хязгааргүй олон - монголжин угсаатан – эзэмших газар”-ын бүтэн цогц агуулгаас харахад, эдгээр орчуулсан нэр томъёонууд дотор газар нутгийн чанартай хэл соёлын орчны дадал заншлын талаархи ташаа ойголт болоод хамгийн гол нь цаг хугацаа үе шатны хувьд оновчгүй байна.

е) “**大朝蒙古国**”, “**大朝**” зэрэг эдгээр нэр томъёонууд Хятадын түүхийн эх сурвалж бичигт үндэслэсэн бөгөөд “Их Монгол Улс” энэхүү 13-р зуунд оноосон улсын нэрийг тухайн үед шууд орчуулах журмаар хятад хэлнээ орчуулсан. Эдгээр орчуулсан нэр томъёонуудыг Хятадын түүхийн хэллэгийн хэл соёлын орчны талаас ойлговол, хятад хэлний соёлын орчин болоод хятад хэлний түүхийн хэллэгийн үзэл суртлын талаас оноон тогтоогдсон. “Их Монгол Улс” энэхүү 13-р зуунд тогтоосон улсын нэрийн монгол хэлний үгийн утга санаа “**极多的一蒙古式族体的一地域领地** - хязгааргүй олон – монголжин угсаатан – эзэмших газар”-ын бүтэн цогц агуулгаас харахад, эдгээр орчуулсан нэр томъёонуудад хятад хэлний хэвшсэн дүрмийн асуудал болоод хамгийн гол нь тухайн цаг хугацаа үе шатан дахь засаг захиргаа, хууль тогтоомжоор хятад хэлээр тусгайлан оноосон улсын нэр томъёо. Хятадын Үндэсний музейн судлаач Юй Цай Чи “**大朝通宝**” зоосон мөнгө<sup>13</sup> (Зураг 3, 4), “**大朝蒙古国**” хөшөөний сийлбэр дармал олоод түүхийн сурвалж материалыг магадлан нотолсноор “**大朝蒙古国**”, “**大朝**” нь 1271 онд Хубилай хаан (Жи жен 8 жил) улсын нэрийг “**大元**” гэж өөрчлөхөөс өмнөх Чингис хааны байгуулсан язгууртан засгийн эрхэт улсын нэр мөн гэж үзсэн байна.<sup>14</sup> Мөн энэ хятад хэлнээ орчуулсан улсын нэр нь 1206-1271 он хүртэл түүхийн цаг хугацааны 65 жилийн туршид хэрэглэгдсэн бөгөөд “**大朝蒙古国**”, “**大朝**” нь тухайн үеийн эзэмшил харьяат газар дотор (хятад үндэстэн доторхи янз бүрийн үндэстнийг хамруулаад) нийтээр хүлээн зөвшөөрөгдөн бий болсон. Энэ нэрийг 13-р зууны Өгөдэй хааны үеийн хятад хэл дээр хийсэн зоосон мөнгө, хөшөөний сийлбэр, ном материалууд дээрээс харж болно. Эдгээрийг өнөөдөр зөвхөн монгол хэл дээр тулган үзэх нь дутагдаж байна. Яагаад “**大朝蒙古国**” энэ үгийг хятад хүний төсөөллөөр “**大朝**” гэж орчуулсныг Тайваний судлаач Сяо Чи Чин

гуай судалж “Үүний учир нь “**大蒙古国**” энэ үгийн үндэстний утга санаа илэрхий хэт хүчтэй, хятадын эгэл ард хүмүүсийг удирдахад хангалтгүй гэж үзээд “**大朝**” гэж товчилсон. “**大朝**” нэр нь Хятадын дунд нутгийн Ван гүрний соёлын орчны утга санааг агуулсан болохоос “**大蒙古国**” гэсэн гадаадын байлдан дагуулагчдын утга санаа биш” гэж үзсэн.<sup>15</sup> Эндээс орчуулагчид болоод хэрэглэгчид энэ орчуулсан нэр томъёоны зааж байгаа утга санаа болон ургуулан бодох утга санааг (мөн хэл соёлын орчин дээр) гүн гүнзгий нарийн ойлгосон, цаашлаад монгол хэлний үгийн санг хятад хэлний соёлын орчинд орчуулсан орчуулга дээрээс нийгэм болоод сэтгэхүйн чадавхийн талаар ойлголт болоод мэдлэг байсныг харж болно. Мөн үүнийг хэл соёлын орчин дахь нийгэм болоод сэтгэхүйн чадавхи нь өөр өөр хэлний хооронд маш их зөрөөтэй байна гэж үзэж болно.


3. Судлаачийн хятад хэл дээр орчуулагдсан “Их Монгол Улс” энэхүү 13-р зууны монгол хэлээр тусгайлан оноосон улсын нэрийн утга санааны талаархи үзэл бодол:

Дээр өгүүлсэнэд үндэслээд судлаач 1206 оноос хойш монгол хэлээр анх удаа албан ёсоор оноон хэрэглэсэн “Чингис хаан”-ны нэр болоод түүний байгуулсан “Монгол Улс”, “Их Монгол Улс”-ын улсын нэр томъёо нь монгол хэлний үгийн утга санаа “**极多的一蒙古式族体的一地域领地** - хязгааргүй олон -монголжин угсаатан - эзэмших газар”-ын бүтэн цогц агуулгаас харахад, хятад хэл дээр “**合众蒙古国**” (The Unite Mongolia States) гэж дүйцүүлэн орчуулж болохоор байна. Гэвч орчин үеийн хятад хэлний хэл зүйн бүтцийг мөрдвөл “**蒙古合众国**” (The Unite Mongolia States) эсхүл “**蒙古合众汗国**” (The Unite Mongolia khans States) гэж тохируулж болно. Хэрэв ингэж ойлгож чадвал, түүхэн бодит байдал, тухайн үеийн монгол хэлний соёлын орчин болоод нийгмийн бодит байдалд бүр илүү ойр дөхөж очих болно. Цаашлаад монгол хэлний үгийн гарал, соёлын утга санааны талаархи ойлголт болоод мэдлэгт бүр сайн тохирно.


Ямар ч хэлний орчуулга нь өөр хоорондоо харилцан ойлголцож нэвтрэлцэх явдал бөгөөд хэрвээ түүний жинхэнэ түүхийн бодит байдал алдагдвал, түүнийг зөв зохистой тайлбарлах болон ойлгох боломжгүй болохоос гадна ямар ч орчуулга нь тухайн цаг үеийн бодит байдалтай нарийн холбоотой байдаг. Өнөө үеийн янз бүрийн хэлний хоорондын харилцааны бодит байдал нь өөр хоорондоо баялаг шинэлэг байдлаар харилцах, шинэ соргог санааг эрэлхийлэх, харилцан зөвөөр ойлголцох зорилготойн сацуу “Хэл нь маш өргөн цар хэмжээнд тодорхой зарчимд нөхцөлдөн хязгаарлагддаг. Гэхдээ хэл бол нэг нээлттэй систем, шинэлэг талыг хэрэглэн хэлний арга ухааны өргөн цар хүрээтэй орон зайг олгосноор




мэдээллийг тасралтгүй дамжуулах боломжтой болно”.<sup>1</sup> Иймд хэрвээ одоо хятад хэл дээр монгол судлалын зарим тусгай нэр томъёог зөв зүйтэй оноон тогтоож чадахгүйгээр дураараа аялга тааруулах, шууд, өөрчлөн найруулах, утга санаагаар орчуулах зэрэг журмаар хөрвүүлбэл эрдэм судлалын ажлын агуулга болон хэлэлцүүлэг, харилцааны тал дээр үзэл бодлын үл ойлголцол, эцэст нь ямар ч тодорхой зарчим олдохгүй, үл ойлголцох эсрэг тэсрэг байдал бий болно. Ингэж ямар ч шаардлагагүй үл ойлголцох байдал бий болох нь судалгааны ажлыг хүндрүүлэх муу талтай. Иймд Хятад улс олон улсын монгол судлалын гол төвийн хувьд монгол судлал дахь тусгай нэр томъёоны хятад хэл дээрх орчуулгын тал дээр тодорхой дүрэм журам гаргаж, цаашид гүн гүнзгий нарийвчлан оноон тогтоох нь ирээдүйн судлаачдын судалгааны ажлын тохиромжтой нөхцлийг бүрдүүлэх болно гэж үзэж байна.



Зураг 1



Зураг 2



Зураг 3



Зураг 4

## ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. 巴拉吉尼玛、额尔敦扎布、张继霞编：《千年风云第一人》—世界名人眼中的成吉思汗，民族出版社，北京，2003年1月第一版，第1页。
2. 见“元朝秘史”，明代堪本，第202节，旁译“达达百姓”，“太祖皇帝”。
3. 道布整理，转写，注释，巴·巴根校：《回鹘式蒙古文文献汇编》（蒙文），北京，民族出版社，1983年6月第一版，第15-17页，《贵由汗汗玺印鉴》。
4. 尤金A.奈达[美]著，严久生译，陈健康校译：“语言文化与翻译”，内蒙古大学出版社，1998年10月第一版，第1页。
5. 道润梯步著：“新译简着《蒙古秘史》”，内蒙古人民出版社，1978年10月第一版，第2页。
6. 拉施特[波斯]主编：“史集”第一卷，第一分册，余大均，周建奇译，商务印书馆出版，1983年1月第一版，第166-167页。
7. 萧启庆主编：“蒙元的历史与文化”—蒙元史学术研讨会论文集，台湾学生书局出版，2001年2月第一版，第256页。
8. 志费尼：《世界征服者史》，第45页。
9. 亦邻真：《中国北方民族与蒙古族族源》，内蒙古大学学报，1979年第3-4期。
10. Anthony D.Smith: (THE NATION in HISTORY)—Historiographical Debates about Ethnicity and Nationalism, Published for Brandeis University Press By University Press of New England, Hanover, 2000.
11. 尤金A.奈达[美]著，严久生译，陈健康校译：“语言文化与翻译”，内蒙古大学出版社，1998年10月第一版，第8页。  
“The functions of language are of two basic types: psychological and sociological. The psychological functions may be described as the means by which people negotiate with reality, and the sociological functions can be said to be those ways by which people negotiate with other persons. The psychological functions may be regarded as essentially internal or subjective, and the sociological functions as external and interpersonal.” jpp179-180
12. 《大蒙古国海云禅师碑》，现存于北京塔源寺。
13. “大朝通宝”钱与“大朝蒙古国”碑刻拓片，国家一级文物，现存于中国国家博物馆。
14. 于采吉：《蒙古汗国国号“大朝”考》，内蒙古社会科学（汉文版）2006年11月，第26卷第6期。
15. 萧启庆：《说“大朝”：元朝建号前的蒙古汗国国号—兼论蒙古汗国国号的演变》，《汉学研究》第3卷第1期。
16. 尤金A.奈达[美]著，严久生译，陈健康校译：《语言文化与翻译》，内蒙古大学出版社，1998年10月第一版，第156页。